



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 6/20

Чингис хот

Н.Ган-Адъяад жирэмсний болон
амаржсаны амралт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр хөдөө аж ахуй, хүнс худалдаа үйлчилгээний бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Ган-Адъяагийн хүсэлтийг үндэслэн 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс жирэмсний болон амаржсаны амралт олгосугай.

2. Үйлдвэр хөдөө аж ахуй, хүнс худалдаа үйлчилгээний бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргалыг томилсугай.

3. Мэргэжилтэн Н.Ган-Адъяагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Саруултөгс	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-эрдэнэ/-д даалгасугай

ДАРГА



Ж.ТАНБААТАР